

## АЖЛЫН ДААЛГАВАР

Төслийн нэр	Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл, IDA credit-P174116
Байршил	Монгол Улс, Улаанбаатар
Ажлын даалгаврын нэр	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах зөвлөх
Гэрээний төрөл	Хувь зөвлөх үйлчилгээ – хуулийн зөвлөх
Хэл:	Монгол
Гэрээний хугацаа:	6 сар

### ҮНДЭСЛЭЛ

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ГБХНХЯ) нь “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл”(ОБУДХЭТ)-ийг Дэлхийн банкны Олон Улсын Хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө болон техникийн дэмжлэгтэйгээр 2020-2025 онд хэрэгжүүлж байна. Төсөл нь ажил хайгч болон бичил бизнес эрхлэгчдэд хөдөлмөрийн зах зээл дэх боломжийг хүртээмжтэй хүргэх, КОВИД-19 цар тахлаас үүссэн хямралын үед зохих шалгуур хангасан албан журмын даатгуулагчдад нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх зорилготой.

Төсөл нь үндсэн 4 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ:

- (1) Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үйлчлүүлэгч төвтэй болгон хөгжүүлэх;
- (2) Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийг бэхжүүлэх;
- (3) Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, дүн шинжилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;
- (4) КОВИД-19 цар тахлын үед зохих шалгуур хангасан албан журмын даатгуулагчдад тодорхой хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

Бүрэлдэхүүн хэсэг 3-ын хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.2.1-д “Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний нэгдсэн бодлогыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эрх зүйн орчныг шинэчилж, салбар хоорондын хамтын ажиллагаа, бодлогын уялдааг хангана.” гэж заасан.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 100-д “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай (Шинэчилсэн найруулга)” гэж туссан зэрэг нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үндэслэл болж байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалж, хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулан Хүуль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран батлуулаад байна.

Хуулийн төслийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төрөл, хамрах хүрээг өргөжүүлэн, үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээний зарчимд шилжих боломжийг тусгаад байна. Түүнчлэн гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн механизмыг ашиглах, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зөвхөн төрөөс бус, хувийн хэвшил, ажил олгогчид, боловсролын байгууллагуудтай хамтран үзүүлэх боломжийг тодорхойлсон.

Иймд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх, эх бичвэрийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцох,

Засгийн газрын санал зөвлөмжийг тусган хуулийн төслийг эцэслэн боловсруулах үндэсний зөвлөхийг богино хугацаанд ажиллуулах саналтай байгаа юм.

Энэхүү ажлын даалгавар нь хууль тогтоомжийн төслийг эцэслэн боловсруулах үндэсний зөвлөхийн ажлын цар хүрээ, нийлүүлэх бүтээгдэхүүн болон тайлагналтыг тодорхойлно.

## ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

**АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ:** Зөвлөх үйлчилгээ нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн хуульд заасан шаардлагын дагуу боловсруулахад чиглэнэ. Энэ хүрээнд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэн, бүтэц/бичвэрийг засварлаж, холбогдох зардлын тооцоог хийн, бусад холбогдох хуульд оруулах нэмэлт өөрчлөлт, тэдгээрийг дагаж гарах шийдвэрийн төслийн хамт боловсруулна.

**ГҮЙЦЭТГЭХ АЖЛУУД:** Зөвлөх дараах ажлуудыг гүйцэтгэнэ:

**А. Хууль эрх зүйн шинжилгээ болон хууль тогтоомжийн төсөл:**

1. Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн дагуу хуулийн зөвлөх нь хуулийн төслийн нөлөөллийн үнэлгээг хийнэ. Хуулийн төслийн үр нөлөөг уг хуулийн 12.1.3-д заасан аргачлалын дагуу дараах байдлаар үнэлж, зөвлөмж гаргана:

- хууль тогтоомжийн төсөл, эсхүл түүний зарим зүйл, заалтын зохицуулалтын практикт хэрэгжих боломж, харилцан уялдаа зэргийг тооцож шинжилгээ хийх;
- хууль тогтоомжийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах;
- хууль тогтоомжийн төслийг батлан хэрэгжүүлснээр үүсэж болзошгүй, урьдчилан тооцоогүй үр дагаврыг тодорхойлох;
- хууль тогтоомжийн төслийн хүний эрхэд нөлөөлөх байдлыг үнэлэх.

Хуулийн төслийг батлан хэрэгжүүлснээр гарах үр нөлөөг тооцсоны үндсэн дээр шаардлагатай бол тухайн хуулийн төсөл, эсхүл түүний зарим зүйл, заалтыг дахин боловсруулна.

2. Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.1-д заасан аргачлалын дагуу хуулийн төслийн үзэл баримтлалд нь нийцүүлэн хуулийн төслийн бүтэц/эх бичвэрийг сайжруулан боловсруулна. Хуулийн төслийн агуулга дараах шаардлагыг хангасан байна:

- Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэн, бусад хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх;
- тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх; нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх; нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;
- зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх; хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;
- бусад хуулийн бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах;
- тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх.

Зөвлөх шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна. Хуулийн төсөлд шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад

хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох, зарим үг, өгүүлбэр, тоо, тэмдэгт хасах талаар тусгана.

3. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийт, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд, мэргэжлийн болон судалгааны байгууллагуудтай хийсэн үүлзалт, хэлэлцүүлгийн саналыг хуулийн төслийн эцсийн хувилбарт тусгана.

4. Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн дагуу хуулийн төслийн бүтэц, эх бичвэрийг бүрэн гүйцэд боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхэд бэлэн болгоно.

Зөвлөх нь хуулийн төслийг холбогдох хууль эрх зүйн үнэлгээ, зардлын/эдийн засгийн тооцооны хамт хоорондоо үялдаатай, нийцтэй байдлаар боловсруулах үүрэг хүлээнэ.

#### **Б. Эдийн засгийн тооцоо:**

1. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх явцад холбогдох зардлын тооцоо судалгааг хийнэ.
2. Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг Хууль тогтоомжийн хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно. Зардлын шинжилгээг дараах төрөл тус бүрээр тооцно:
  - a) **Хуулийн этгээдийн зардал:** хуулийн этгээд үг хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан гарах мөнгөн зардлыг тооцно. Тухайлбал, хуульд заасан үйлчилгээг хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх, иргэдэд үйлчилгээ үзүүлэх гэх мэт. Зардлыг тооцохдоо ижил төстэй үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлээс судалгаа авах, ярилцлага, хэлэлцүүлэг хийх зэрэг аргаар шаардлагатай мэдээллийг цуглуулж болно.
  - b) **Иргэний үүсэх зардал:** хуулийг хэрэгжүүлэхэд иргэн тодорхой үүрэг гүйцэтгэж оролцох тохиолдолд энэ зардлыг тооцох ба иргэний гүйцэтгэх үүргийг нэг бүрчлэн тодорхойлж, зарцуулах цаг хугацаа болон өртгийг тооцно.
  - c) **Төрийн байгууллагын зардал:** Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцож гаргах бөгөөд үг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:
    - төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
    - ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
    - гарах зардлыг урьдчилан тооцох;
    - зардлыг нэгтгэн тооцож танилцуулах.

#### **НИЙЛҮҮЛЭХ БҮТЭЭГДЭХҮҮН:**

Зөвлөх доор дурдсан бүтээгдэхүүнийг 2025 оны 07 сарын 30-ны дотор ирүүлнэ:

#### **A. Хууль зүйн зөвлөх үйлчилгээ нийлүүлэх бүтээгдэхүүн:**

1. Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан;
2. Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн тайлан;
3. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эцэслэсэн хувилбар;
4. Дагалдаж өөрчлөлт оруулах хууль тогтоомж, шийдвэрийн төсөл;

#### **B. Эдийн засгийн тооцоо шинжилгээ нийлүүлэх бүтээгдэхүүн:**

1. Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээтэй холбогдох зардлын тооцооны тайлан;
2. Хуулийг хэрэгжүүлснээр үүсэх зардлыг тооцоход ашигласан мэдээ баримт, тоон мэдээлэл, судалгааны тайлан;
3. Хуулийг батлан хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлан.

**ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА:** Гэрээний хугацаа нь 2025 оны 04 дүгээр сарын 15-ээс 2025 оны 09 дүгээр сарын 30-ны хооронд (6 сар) байна.

### **МОНИТОРИНГ, ЯВЦЫН ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛТАД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД:**

Зөвлөх эцсийн бүтээгдэхүүн хүлээлгэн өгөх хугацааг тусгасан ажлын календарьчилсан төлөвлөгөөг боловсруулж гэрээнд хавсаргана. ГБХНХЯ-ны Хөдөлмөрийн бодлогын газрын дарга, хэлтсийн дарга, холбогдох мэргэжилтэн болон ажлын хэсэгтэй байнга холбоотой ажиллана. Мөн Хөдөлмөрийн бодлогын газрын дарга, холбогдох мэргэжилтэн болон ажлын хэсэг нь зөвлөхийн ажлын гүйцэтгэл, үйл ажиллагаанд хяналт тавина.

Зөвлөх нь захиалагчид бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгсөн хэдий ч бүтээгдэхүүний хэрэглээ, сайжруулалттай холбоотой асуудлаар хуулийн төслийг эцэслэж өргөн барих хүртэлх хугацаанд захиалагчтай шаардлагатай үед хамтран ажиллана.

Зөвлөхийн ажлын гүйцэтгэлийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

- 1) Ажлын даалгаварт тусгасан ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн байдал;
- 2) Төлөвлөсөн ажлуудаа хугацаанд нь хэрэгжүүлсэн байдал;
- 3) Гүйцэтгэсэн ажлын чанар.

Зөвлөх нь ГБХНХЯ/TXN болон Дэлхийн банканд ажлын гүйцэтгэлийг тайлagnana. Зөвлөх нь гэрээний төлбөрийн хуваарь заасан төлбөр авахын өмнө ГБХНХЯ болон TXN-д Бүтээгдэхүүн хүлээж авах маягтыг бөглөж ирүүлнэ.

Энэ ажлын даалгаварт заасан аль нэгэн бүтээгдэхүүнийг үндэслэлтэй нөхцөл байдлын улмаас гэрээ дуусгавар болохоос өмнө нийлүүлж амжаагүй бөгөөд үүнээс шалтгаалж гэрээний хугацааг сунгах тохиолдолд зөвлөх нэмэлт зардалгүйгээр бүтээгдэхүүнийг нийлүүлнэ.

**ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ:** Зөвлөх нь тохиролцсон бүтээгдэхүүнийг ГБХНХЯ/TXN-д бүрэн хүлээлгэн өгсний дараа төлбөрийг бүрэн дүнгээр төлнө.

### **ШААРДЛАГАТАЙ УР ЧАДВАР, АЖЛЫН ТУРШЛАГА**

#### **Зөвлөхөд тавигдах шаардлага:**

- Хууль, эрх зүйч мэргэжилтэй, магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой байх;
- Ижил төстэй 2-оос доошгүй хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ судалгаа амжилттай гүйцэтгэсэн туршлагатай;
- Хууль тогтоомжийн төсөл боловсруулах чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай;
- Хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулах ажилд оролцож байсан бол давуу тал болно.

#### **Шаардагдах баримт бичгүүд:**

1. Анкет (Curriculum Vitae) монгол эсвэл англи хэл дээр;
2. Диплом болон холбогдох гэрчилгээний хуулбарууд\*;
3. Иргэний үнэмлэхийн хуулбар\*;
4. Ижил төстэй туршлагыг батлах тодорхойлолт лавлагаа эсвэл зөвлөмжийн захидал;
5. Ажиллах хүсэлт (Cover Letter) бичгээр монгол эсвэл англи хэл дээр;
6. Танай чадварыг батлахад туслах нэмэлт баримт бичгүүд.